



ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Х.Бекен
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Ахлах аудитор:
М.Айнур
Утас: 94159291
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Аймгийн ЗДТГ
Байршил: Өлгий сум 5-р баг
Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 3 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт
18. Санхүүгийн тайлангийн дансдын талаар

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн аудитын газраас Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд (БӨА-2018/2/СТА-ОНӨААН/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Цахилгаан шугам сүлжээний газрын удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 20-ноос 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Баян-Өлгий аймгийн аудитын газрын аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 05-нд Аймгийн аудитын газарт ирүүлсэн.

Аймгийн аудитын газраас Цахилгаан Шугам Сүлжээний газарт цаг хугацааны хязгаарлалтын улмаас завсарын аудит хийгдээгүй бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 3 дугаар сарын 07-ноос 3 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 19-нд Цахилгаан шугам сүлжээний газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Цахилгаан шугам сүлжээний газар нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль бусад холбогдох хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Дэвшилтэт технологийг нэвтрүүлэн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай түгээн хангаж, хэрэглэгчдээ дээдлэн ажиллах” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ хуулийн 14, 16, 17, 21 дүгээр зүйлд заасан эрх эдэлнэ” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлд төрийн өмчийн хуулийн этгээдийн захирлын эд хөрөнгийн эрх, үүргийг заасан байна. Цахилгаан шугам сүлжээний газрын дарга ОНӨХЭ-ийн захирлын үүргийг гүйцэтгэж байна. Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, төсвийг байгууллагын Удирдах зөвлөлөөс хянаж баталдаг ба Цахилгаан шугам сүлжээний газрын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Цахилгаан шугам сүлжээний газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Цахилгаан шугам сүлжээний газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Цахилгаан шугам сүлжээний газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цахилгаан шугам сүлжээний газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм Цахилгаан шугам сүлжээний газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Шилэн дансны мэдээлэл

Цахилгаан шугам сүлжээний газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад эрсдэлтэй асуудал тогтоогдоогүй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны батлагдсан төсвийг shilendans.gov.mn вэб сайтад байршуулсан байна. Төсвийн талаарх мэдээллийг байгууллагын самбарт байршуулжээ.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөгөөр 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар тус байгууллага шилэн дансны тухай хуулийн 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.4.1, 6.4.5-т заасан заалтуудыг зөрчсөн 4876.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч биелэлтийг 2017.12.07 №01/473 тоот албан тоотоор авч хангуулсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 30 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, санхүүжилт, бусад орлого, касс, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ, НӨАТ, тээвэр шатахуун, ББЭХ-ний тооцоо зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад алдаа зөрчил илэрээгүй байна.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил илэрээгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад цаг хугацааны хязгаарлалтаас бүрэн гүйцэд мөшгин шалгах боломжгүй байсан учир гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай байна. Тухайлбал:

Касс, харилцахын 8 дансны сарын нийт дүнгээр түүвэр сорил хийсэн ба өдрийн хуулгын дүнг тулгах боломжгүй байсан, мөн цалингийн урьдчилгаа, байгууллага, хүмүүстэй хийх тооцоо, цалингийн тооцоолол, жолооч нарын тооцоо гэх мэт зардлуудыг гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын санхүүгийн тайланд зөвлөмж өгөгдөөгүй байна

Зөрчилгүй санал дүгнэлт

газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, менежментийн захидал ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:

Х.ЖЕНИСБЕК

Огноо:

Х.МАНАРГҮЛ

Огноо: 2018.03.15